

2023 он 8 сар 25 өдөр

Дугаар 23/23

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Хувьцааны хяналтын багц худалдан авах санал гаргах тухай*

Компанийн тухай хуулийн 56.2, 76.1, 80.4 дүгээр заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1, Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журам, ТУЗ-ийн 2023 оны 8 сарын 25-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компани нь хөрөнгө оруулалтын зорилгоор Хөвсгөл ХК (HVL)-ийн нийт гаргасан энгийн хувьцаанаас 48,690 ширхэг буюу хяналтын багцыг худалдан авах саналыг Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 03 сарын 20-ны 38 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам”-д заасны дагуу сайн дурын үндсэн дээр гаргахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1.-д заасан хувьцааг сайн дурын үндсэн дээр худалдан авах санал гаргахтай холбоотой мэдэгдэлд санал болгож буй үнэ 84 төгрөг, худалдан авах саналын эхлэх хугацааг 2023 оны 8 дугаар сарын 28-ны өдөр, дуусах хугацааг 2023 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр, хувьцааны худалдан авах төлбөрийн хугацааг 2023 оны 10 дугаар сарын 2-ны өдөр тус тус байхаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж холбогдох арга хэмжээг авч, зардлыг компаниас гаргахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Б. Золбоо)-д, хяналт тавьж ажиллахыг Дотоод Аудитор (М.Мөнх-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ